

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:	“АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт Бөөр орлуулах эмчилгээний аппарат нийлүүлэх” – Багц 1
Тендер шалгаруулалтын арга:	Харьцуулалт
Тендер шалгаруулалтын № :	MN-MoH-332103-GO-RFQ
Төсөл:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл
Санхүүжүүлэгч:	Дэлхийн банк, 100 хувь санхүүжүүлнэ.

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

Урилгын огноо:	2022.12.20-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр:	“АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт Бөөр орлуулах эмчилгээний аппарат нийлүүлэх” – Багц 1
Тендер шалгаруулалтын арга:	Харьцуулалт
Тендер шалгаруулалтын № :	MN-MoH-332103-GO-RFQ
Төсөл:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл
Санхүүжүүлэгч:	Дэлхийн банк, 100 хувь санхүүжүүлнэ

1. Эрүүл мэндийн яам нь Дэлхийн банкны санхүүжилттэй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд, эрх бүхий хуулийн этгээдийг “АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт Бөөр орлуулах эмчилгээний аппарат нийлүүлэх”- Багц 1 ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн үнийн санал ирүүлэхийг урьж байна. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг энэ үнийн саналын урилгад хамруулсан:

Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээний аппарат (Continuous renal replacement therapy) – 1 иж бүрдэл
Гемодиализын усны аппарат (Portable Hemodialysis water treatment equipment) – 1 иж бүрдэл

2. Энэ харьцуулалтын аргаар явуулах тендер шалгаруулалтыг Дэлхийн банкны “Procurement Regulations for IPF Borrowers” November 2020 edition (“Procurement Regulations”) журмын дагуу хэрэгжүүлнэ.

3. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

4. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

5. Уг тендер шалгаруулалт нь багцгүй болно.

6. Сонирхогч этгээд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Сонирхогч этгээд нь 9 дүгээр зүйлд заасан заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 70,000 төгрөгийн эргэн үл төлөгдөх хураамжийг төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн Үнийн саналын баримт бичгийг авч болно. Төлбөрийг доорх дансанд шилжүүлнэ /төлбөрийн даалгавар дээр тендер шалгаруулалтын дугаарыг заавал бичнэ/.

Хүлээн авагчийн банк: Төрийн сангийн банк
Төгрөгийн данс: 100900011981

Дансны нэр: Ковид-19-с УСХАХАББХТөсөл

7. Хураамжаа төлсөн этгээдэд Үнийн саналын баримт бичгийг цахим шуудангаар /и-мэйл/ илгээнэ.

8. Тендерийн баталгаа ирүүлэх шаардлагагүй.

9. Танай компани нь дараах чадварын болон бусад шалгуурыг хангах шаардлагатай:

- (1) Энэ сонгон шалгаруулалтын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зохиосон хувь хүн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд биш байх. Энэ талаар үнийн саналын маягтад зааж ирүүлнэ.
- (2) Үнийн санал нь түүнийг нээснээс хойш 40 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байх. Энэ талаар үнийн саналын маягтад заана.
- (3) Графикт заасан хугацаанд барааг нийлүүлсэн байх: Гэрээний барааг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш хуанлийн 110 хоногт багтаан эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгсөн байна. Энэ талаар Үнийн саналын маягтад зааж ирүүлнэ.
- (4) Тусгай зөвшөөрөлтэй байх. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдах импортлох, ханган нийлүүлэх, худалдах хуулбарыг үнийн саналын хамт ирүүлэх шаардлагатай.
- (5) Үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй байх. Тоног төхөөрөмжийн нэр зүйл бүрээр Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл албан ёсны төлөөлөгч болохыг нотолсон баримт бичгийг үнийн саналын хамт ирүүлнэ.
- (6) Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн чиглэлээр мэргэшсэн доод тал нь 1 инженертэй байх: инженерийн чадвар, боловсрол, ажлын туршлагыг харуулсан намтар, мэргэжлийг илтгэх боловсролын диплом, үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.
- (7) Монгол Улсын хуулийн дагуу төлөх татвар, хураамжийн хувьд үнийн санал нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргүй байна. Цахим систем, Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлтийн байдлыг тендер нээсэн өдрийн байдлаар шалгана.
- (8) Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээ: үүнийг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцно. Энэхүү зөрүү нь дор хаяж 2021 оны хувьд эерэг байвал зохино. 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
- (9) Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 41,300,000 төгрөгөөс багагүй байх бөгөөд харилцагч банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт, шугаман зээлийн эрхийн үлдэгдлийн тодорхойлолтоор тооцно. Судлан үзэх болон шалгарсан тохиолдолд олгох боломжтой тухай тодорхойлолтыг тооцохгүй.
- (10) Борлуулалтын орлогын жилийн дундаж хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2020, 2021 оны дундаж борлуулалтын хэмжээ нь 343,800,000 төгрөгөөс багагүй байна. 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
- (11) Ижил төстэй ажлын туршлага: 2020, 2021 оны хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн доод тал нь 1 гэрээтэй байх, нийт гэрээний үнийн дүн нь 82,500,000 төгрөгөөс багагүй байх. Гэрээний хуулбарыг, захиалагчийн хүлээн авах актын хамт ирүүлнэ. “Ижил төстэй гэрээ” гэдэгт Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн гэрээг

ойлгоно.

- (12) Санал болгосон тоног төхөөрөмж нь үнийн хуваарьт заасан захиалагчийн техникийн тодорхойлолтыг биелүүлсэн байх. Үнийн хуваарийг бөглөх, тоног төхөөрөмж шаардлагад нийцсэн болохыг нотлон харуулах танилцуулга, каталог, гарын авлага, стандартын гэрчилгээг ирүүлнэ. Хэрэв тендерт оролцогч нь захиалагчийн шаардсан техникийн үзүүлэлтээс бага зэрэг зөрсөн, гэхдээ үндсэндээ ижил тоног төхөөрөмж, багаж санал болгосон ба энэ тоног төхөөрөмж, багаж нь шаардсан техникийн үзүүлэлтийн чиг үүргийг гүйцэтгэж чадна хэмээн Захиалагч үзвэл, тухайн барааг шаардлагад нийцсэн хэмээн Захиалагч хүлээн зөвшөөрнө. Хэтрүүлэн биелүүлсэн техникийн үзүүлэлт бүхий тоног төхөөрөмж санал болгосон үнийн саналыг үнэлгээнд давуу эрхтэйгээр авч үзэхгүй.
- (13) Тендерт оролцогч нь Хуулийн этгээдийн өмчлөгчийн тухай мэдээллийг Үнийн санал авах баримт бичгийн маягтын дагуу ирүүлнэ.

10. Үнийн саналын баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Дэлхийн банкны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
Хаяг: УБ, СБД, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 11-р давхар, 1103 тоот
Утасны дугаар: 7707-7793, Цахим шуудангийн хаяг: munkh@ehp.mn

ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Дэлхийн банкны Зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам”-ын 3.21-3.23 дугаар зүйл болон Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) ТШӨХ-д дурдагдсан бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 40 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

**7. Санал
болгосон
үнэ, түүнийг
үнэлэх**

- 7.1. ҮНЭ: Үнийн саналыг төгрөгөөр илэрхийлж ирүүлнэ. Гэрээний төлбөрийг төгрөгөөр хийнэ. Үнийн саналын үнэ нь Гэрээний хэрэгжилтийн хугацаанд тогтмол байна. Үнийн хуваарьд заасан бүх нэр зүйлсийг бүх тоо ширхгээр үйлдвэрлэх, захиалах, худалдан авах, эцсийн цэгт тээвэрлэн хүргэх, холбогдох даатгал хийлгэх, техникийн урьдчилсан дүгнэлт гаргуулах, угсарч, зүгшрүүлэн эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгөх, Үнийн хуваарьт заасан бол холбогдох сургалт явуулах, ашиглалт болон үйлчилгээний гарын авлагыг хүлээлгэн өгөх, баталгаат засварын үүрэг хариуцлагыг биелүүлэх, бусад зардал, ашиг зэргийг Үнийн саналд шингээж ирүүлнэ. Үнийн саналд дараах зардлыг шингээхгүй: (1) гаалийн импортын үед тоног төхөөрөмж, бараанд оногдуулдаг НӨАТ, гаалийн татвар, (2) захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ. Тайлбар: тендерт оролцогч нь гаалийн тэмдэг дарсан баглаа боодлын жагсаалт, нэхэмжлэх, тээврийн манифест зэргийг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 7 хоногийн хугацаанд гаалийн баталгаат агуулах, талбайд бараа хадгалах зардлыг Үнийн саналд тооцож шингээнэ. Энэ ажлын 7 хоногт багтаан захиалагч нь тухайн барааг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх юм.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 8.2. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Захиалагч: Эрүүл мэндийн яам</p> <p>Тендерийн дугаар: MN-MoH-332103-GO-RFQ</p> <p>Тендерийн нэр: “АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт Бөөр орлуулах эмчилгээний аппарат нийлүүлэх” – Багц 1</p> <p>Санхүүжилтийн эх үүсвэр: Дэлхийн банкны санхүүжилттэй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл</p>
ТОӨЗ 1.1	<p>“Дэлхийн банкны Зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам”-ын 3.21-3.25 (Тендерт оролцох эрх, Худалдан авалтын зөрчил), 3.32 (Авлига, хээл хахууль) болон 5.94 (Гэрээ байгуулах эрх олгох) дугаар зүйлүүд болон Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. Дэлхийн банкны дээр дурьдагдсан заалтуудыг http://pubdocs.worldbank.org/en/178331533065871195/Procurement-Regulations.pdf холбоосоор орж танилцсан байх шаардлагатай.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>2023.01.19-ний өдрийн 9:30 цаг /Улаанбаатарын цагаар/ болно.</p> <p>Тендер хүлээн авах хаяг нь: Дэлхийн банкны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 11-р давхар, 1103 тоот</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хугацаа нь:</p> <p>2023.01.19-ний өдрийн 9:30 цаг /Улаанбаатарын цагаар/ болно.</p> <p>Тендерийн нээлт хийх хаяг нь: Дэлхийн банкны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 11-р давхар, 1103 тоот</p>
ТОӨЗ 3.1	<p>Тендерт оролцогч нь дараах үндсэн болон нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын хуулийн дагуу төлөх татвар, хураамжийн хувьд үнийн санал нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргүй байна

2. Цахим систем, Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлтийн байдлыг тендер нээсэн өдрийн байдлаар шалгана.
3. Үнийн хуваарь болон бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.
4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.
5. Тусгай зөвшөөрөлтэй байх. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдах импортлох, ханган нийлүүлэх, худалдах хуулбарыг үнийн саналын хамт ирүүлэх шаардлагатай.
6. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй байх. Тоног төхөөрөмжийн нэр зүйл бүрээр Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл албан ёсны төлөөлөгч болохыг нотолсон баримт бичгийг үнийн саналын хамт ирүүлнэ.
7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн чиглэлээр мэргэшсэн доод тал нь 1 инженертэй байх: инженерийн чадвар, боловсрол, ажлын туршлагыг харуулсан намтар, мэргэжлийг илтгэх боловсролын диплом, үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.
8. Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээ: үүнийг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцно. Энэхүү зөрүү нь дор хаяж 2021 оны хувьд эерэг байвал зохино. 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
9. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 41,300,000 төгрөгөөс багагүй байх бөгөөд харилцагч банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт, шугаман зээлийн эрхийн үлдэгдлийн тодорхойлолтоор тооцно. Судлан үзэх болон шалгарсан тохиолдолд олгох боломжтой тухай тодорхойлолтыг тооцохгүй.
10. Борлуулалтын орлогын жилийн дундаж хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2020, 2021 оны дундаж борлуулалтын хэмжээ нь 343,800,000 төгрөгөөс багагүй байна. 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
11. Ижил төстэй ажлын туршлага: 2020, 2021 оны хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн доод тал нь 1 гэрээтэй байх, нийт гэрээний үнийн дүн нь 82,500,000 төгрөгөөс багагүй байх. Гэрээний хуулбарыг, захиалагчийн хүлээн авах актын хамт ирүүлнэ. “Ижил төстэй гэрээ” гэдэгт Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн гэрээг ойлгоно.
12. Бараа нь технологийн хувьд орчин үеийн, дэвшилтэт технологи байхын сацуу ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан байх бөгөөд холбогдох чанарын сертификатыг ирүүлнэ.
13. Нийлүүлэх тоног төхөөрөмжийн зураг, каталогийг ирүүлнэ.

	<p>14. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл, техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгтийг ирүүлнэ.</p> <p>15.Тендерт оролцогч Хуулийн этгээдийн өмчийн эзэмшлийн тухай мэдээллийг холбогдох хавсралт маягтын дагуу ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 4.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна”.
ТӨӨЗ 5.1	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл, техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгтийг ирүүлнэ.
ТӨӨЗ 6.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 40 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Үнийн саналыг ирүүлэхдээ үндсэн тоног төхөөрөмж болон дагалдах хэрэгслийн үнийг нэгтгэж, маягтын дагуу төгрөгөөр ирүүлнэ.
ТӨӨЗ 7.1	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ-ны 15.9. (б). (1) дэх хэсэгт заасан СІР үнэ байна. Тендерт оролцогч барааны үнэд ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэгт тээвэрлэх зардал, даатгал, татвар, хураамж, суурилуулах зардлыг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. Олон улсын худалдааны Инкотермс-ийн хувилбар: Incoterms 2020.
ТӨӨЗ 8.1	Захиалагч шаардлагатай гэж үзвэл барааны тоо хэмжээг 15 хувиар өсгөх эсвэл бууруулах эрхтэй.
ТӨӨЗ 8.2	Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Техникийн тодорхойлолтыг 1-р хавсралтаас харна.
2. **Бараа хүргэх газар / эцсийн цэг:** Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Монгол-Японы сургалтын эмнэлэг. Хаяг. 13270, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 12-р хороо, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн
3. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермсийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Continuous renal replacement therapy - Үргэлжилсэн бөөр орлуулах эмчилгээний аппарат	1	ширхэг	Монгол-Японы сургалтын эмнэлэг	20 хоног	110 хоног	
2	Portable Hemodialysis water treatment equipment - Гемодиализын усны аппарат	1	ширхэг	Монгол-Японы сургалтын эмнэлэг	20 хоног	110 хоног	

ТАВ. ЖИШИГ МАЯГТ

МАЯГТ 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Үнийн саналд дараах зардлыг шингээгээгүй: (1) гаалийн импортын үед тоног төхөөрөмж, бараанд оногдуулдаг НӨАТ, гаалийн татвар, (2) захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ. Тайлбар: бид гаалийн тэмдэг дарсан баглаа боодлын жагсаалт, нэхэмжлэх, тээврийн манифест зэргийг захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 7 хоногийн хугацаанд гаалийн баталгаат агуулах, талбайд бараа хадгалах зардлыг Үнийн саналд тооцож шингээсэн. Гэрээний төлбөр төгрөгөөр хийгдэнэ.
3. Гэрээний төлбөрийг төгрөгөөр хийх болон Үнийн саналын үнэ нь Гэрээний хэрэгжилтийн хугацаанд тогтмол байхыг бид хүлээн зөвшөөрч байна. Үнийн хуваарьд заасан бүх нэр зүйлсийг бүх тоо ширхгээр үйлдвэрлэх, захиалах, худалдан авах, эцсийн цэгт тээвэрлэн хүргэх (Инкотермс 2020 CIP), холбогдох даатгал хийлгэх, техникийн урьдчилсан дүгнэлт гаргуулах, угсарч, зүгшрүүлэн эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгөх, Үнийн хуваарьт заасан бол холбогдох сургалт явуулах, ашиглалт болон үйлчилгээний гарын авлагыг хүлээлгэн өгөх, баталгаат засварын үүрэг хариуцлагыг биелүүлэх, бусад зардал, ашиг зэргийг Үнийн саналд тооцож шингээсэн.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 40 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
5. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
6. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
7. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж гэрээний үнийн дүнгийн хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхээ амлаж байна.
8. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

9. Бид болон гэрээний гүйцэтгэлд оролцох аливаа туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь Дэлхийн банкны группийн гишүүн эсвэл Дэлхийн банк болон бусад хөгжлийн банкуудын хооронд байгуулсан Тендер шалгаруулалтын шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу түр хугацаагаар түдгэлзүүлсэн эсвэл хар жагсаалтад орсон байгууллага болон хувь хүнтэй холбоогүй бөгөөд удирдлагад нь ажилладаггүй болно. Түүнчлэн Захиалагчийн орны хууль тогтоомж эсвэл НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу эсвэл албан журамд үл нийцсэн биш болно.
10. Бид Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны 3.21-3.25, 3.32 заалтуудын дагуу Захиалагчтай ямарваа нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгийг мэдэгдэж байгаа бөгөөд энэхүү тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг, материалыг Дэлхийн банкнаас томилон бие даасан аудитораар хянуулахад татгалзах зүйлгүй болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

МАЯГТ 2. ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл бараа хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

МАЯГТ 3. ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

[Тайлбар: Энд дурдсан зааврын дагуу үйлдвэрлэгч энэ маягтыг бөглөнө. Энэхүү зөвшөөрлийг үйлдвэрлэгчийн албан бланк дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. Энэ зөвшөөрлийн агуулгатай ижил төрлийн бусад зөвшөөрлийг шаардлагад нийцсэнд тооцно, жишээлбэл борлуулагч, дилер, дистрибьютер, засвар үйлчилгээний зөвшөөрөл гэх мэт.]

Огноо:

ДӨТШ-ын дугаар: **[оруул: тендер шалгаруулалтын дугаар]**

Хувилбарын дугаар: **[оруул: энэ нь хувилбарт тендер бол ялгах дугаар]**

(Захиалагчийн нэр)-ын дарга _____Танаа

Бид, *[үйлдвэрлэгчийн бүтэн хаягийг оруулах]*-д байршилтай *[үйлдвэрлэгчийн бүрэн нэрийг оруулах]* нь *[үйлдвэрлэдэг/борлуулдаг барааны төрлийг оруулах]*-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд үүгээр *[тендерт оролцогчийн бүтэн нэрийг оруулах]* компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан *[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]* барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийж гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Үнийн хуваарьт заасан чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Нэр ба албан тушаал:

Гарын үсэг зурсан огноо:

Хаяг:

МАЯГТ 4. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Тендерт оролцогч, нийлүүлэгчид өгөх заавар: энэ маягтыг бөглөөд энэ зааврыг устгана уу

Энэ маягтыг бүх тендерт оролцогч бөглөж тендерийн хамт ирүүлнэ.

Шалгарсан тендерт оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох мэдээгдэл аваад энэ маягтыг шинэчилж өгнө. Түншлэлийн хувьд, гишүүн бүрээр энэ маягтыг бөглөнө. Энэ маягтад дурдах мэдээлэл нь тендер ирүүлэх үеийн бодит мэдээллийг агуулна.

Энэ маягтын хуулийн этгээдийн өмчлөгч гэдэгт дараах нөхцөлийн нэг буюу түүнээс олныг нь хангасан эцсийн хувь хүнийг хэлнэ:

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

Тендер шалгаруулалтын нэр:

Тендер шалгаруулалтын №:

Үнийн саналын урилгын дагуу өмчлөгчийн талаарх мэдээллийг доорх байдлаар хүргүүлж байна: *[аль нэг хувилбарыг сонгоно уу]*

Бидний өмчлөлийн мэдээлэл нь дараах болно.

Хувилбар 1

Өмчлөгчийн нэр	<i>Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй (Тийм / Үгүй)</i>
<i>[ургийн овог, овог, нэрийг бүтнээр нь бичих, иргэншил, оршин суугаа улсыг бичих</i>			

Хувилбар 2

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгч байхгүй болохыг бид мэдэгдэж байна:

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

Хувилбар 3

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгчийг тогтоон тодорхойлох боломжгүй болохыг бид мэдэгдэж байна: *[энэ хувилбарыг сонгосон бол, яагаад тодорхойлох боломжгүй талаарх тайлбарыг энд бичнэ]*

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

Тендерт оролцогчийн нэр: *[оноосон нэрийг бүтнээр бичнэ]

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Огноо:

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Нэр томьёо**
- 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
 - (б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
 - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
 - (г) “бусад үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
 - (д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
 - (е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
 - (ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
 - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**
- 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задалж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.

- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 2.4. Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 2.5. Нийлүүлэгч нь Дэлхийн банкны Авлигын эсрэг журмыг заавал мөрдөнө. Захиалагч нь нийлүүлэгчээс тендер шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн явцад туслан гүйцэтгэгч эсвэл түншид төлсөн эсвэл төлөх ёстой төлбөр, шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийг гаргаж өгөхийг шаардана. Тухайн мэдээлэлдээ туслан гүйцэтгэгч эсвэл гуравдагч этгээдийн нэр, хаяг, мөнгөн дүн болон валют, ямар зорилготой төлбөр хийсэн талаар мэдүүлэх ёстой.
- 2.6. Нийлүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, зөвлөхүүд нь Дэлхийн банкнаас томилогдсон этгээдээр гэрээний гүйцэтгэл, тендер шалгаруулалттай холбоотой данс, бүртгэлийг шалгуулах, Дэлхийн банкны томилсон аудитораар аудитлуулахыг зөвшөөрнө. Нийлүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, зөвлөхүүд нь Дэлхийн банкны хяналт шалгалт болон аудитын эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах тохиолдолд байгуулсан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 2.7. Нийлүүлэгч нь өөрийн туслан гүйцэтгэгч болон зөвлөхүүдээс гэрээнд тусгагдсан барааг нийлүүлэхэд зарцуулсан цаг болон зардлыг тооцохуйц боломжтой байхаар данс, бүртгэлийг ойлгомжтой, системтэйгээр хөтлөхийг шаардахад хүчин чармайлт гаргах ёстой.
- 2.8. Гэрээг гүйцэтгэх явцад нийлүүлэгчийн аливаа ажилтан авлига өгөх, залилан мэхлэх, хуйвалдах, албадах эсвэл саад учруулах үйлдэл гаргасан гэж Захиалагч, төслийн менежер эсвэл нийлүүлэгч үзсэн тохиолдолд нийлүүлэгч тухайн ажилтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авна.

3. Захиалгыг өөрчлөх

- 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:
 - (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

(в) барааг хүргэх газар.

- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, нийлүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
- 4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах**
- 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
- 6. Барааны гарал үүслийн улс**
- 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

7. Шалгалт болон туршилт

- 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

8. Баглаа боодол

- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу барааг нийлүүлснээс хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр Инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.

13. Чанарын баталгаа, баталгаат засвар

- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
- 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.

14. Төлбөр

- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

- 15. Үнэ** 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтална. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 16. Хуваарийг сунгах** 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
 - (б) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
 - (в) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
- 17. Алданги оногдуулах** 17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
- 18. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** 18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

- (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
- (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
- (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;
- (г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах 19.1. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.

20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах 20.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.

20.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл

(б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.

20.3. Нөгөө тал гэрээг ноцтой зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Захиалагч эсвэл гүйцэтгэгч гэрээг цуцлах эрхтэй. Захиалагчийн дүгнэлтээр Гүйцэтгэгч нь гэрээ байгуулах эрхийн төлөө өрсөлдөх эсвэл гэрээг гүйцэтгэх явцад авлига өгөх, залилан мэхлэх, хуйвалдах, дарамтлах, саад учруулах үйлдэл гаргасан гэж үзэхийг гэрээг ноцтой зөрчсөн гэж үзнэ. Энэ тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид албан бичгээр мэдэгдэж, 14 хоногийн дотор гэрээг цуцална.

21. Маргааныг шийдвэрлэх

21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.

21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

23. Гэрээний үүргийг шилжүүлэх

23.1. Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

- 24. Гэрээнд ашиглах хэл**
- 24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
- 25. Татвар болон хураамж**
- 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 26. Гарчиг**
- 26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
- 27. Үүргийн гүйцэтгэл**
- 27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Тодорхойлолт (ГЕН - 1)** 1.1. Захиалагч нь Эрүүл мэндийн яам.
- Ажлын талбай: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Монгол-Японы сургалтын эмнэлэг. Хаяг. 13270, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 12-р хороо, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн
- 2. Шалгалт туршилт (ГЕН - 7)** 7.0 Тендерт оролцогч нийлүүлэх бараанд заавал хийгдсэн байх үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт.
- 3. Баглаа боодол (ГЕН - 8)** 8.2 Барааг тээвэрлэхдээ ачааг дараах байдлаар тэмдэглэж хаяглана:
- Дэлхийн банкны санхүүжилттэй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл” /P173799/
Гэрээний дугаар
Эрүүл мэндийн яам
Засгийн газрын VIII байр
Олимпын гудамж 2, 1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот, Монгол Улс 14210
- 4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)** 9.3 Монгол Улсын гаднаас санал болгосон бараа:
- Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагчид бичгээр мэдэгдэж, дараах баримт бичгийг захиалагчид шуудангаар илгээнэ:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон хоёр ширхэг хуулбар хувийг бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн хоёр ширхэг хуулбар хувийн хамт;
 - 3) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;
 - 4) даатгалын гэрчилгээ;
 - 5) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;

6) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;

7) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

9.4 Монгол Улсын дотроос санал болгосон бараа:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;

3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;

4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;

5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)

11.1 Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.

Үнийн хуваарьт өөрөөр заагаагүй бол, чанарын баталгааны хугацаа нь барааг хүлээлгэн өгснөөс хойш доод тал нь 12 сарын хугацаанд үргэлжилнэ. Эцсийн хэрэглэгчийн хүлээн авсан тухай акт гарахад Гүйцэтгэлийн баталгааны дүнг 50% буруулж, тус баталгааг 12 сарын хугацаанд хүчинтэй байлгана.

6. Даатгал (ГЕН - 12)

12.0 Даатгалын тусгай шаардлага

Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх барааны даатгалыг нийлүүлэгч хариуцна.

7. Баталгаат засвар (ГЕН-13)

13.0 Баталгаат засварын тусгай шаардлага

Техникийн тодорхойлолт хэсэгт бараа бүрээр заасан болно.

- 8. Төлбөр (ГЕН - 14)**
- 14.4 Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ:
- Ирсэн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа хүлээлгэж өгснөөс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх, зарлагын падаан болон захиалагч барааг шалгаж хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 14.5 Захиалагч Монгол Улсын дотроос санал болгосон барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ:
- Ирсэн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа хүлээлгэж өгснөөс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх, зарлагын падаан болон захиалагч барааг шалгаж хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 8. Үнэ (ГЕН - 15)**
- 15.1 Гэрээний үнийг тохируулахгүй.
- 9. Алданги оногдуулах (ГЕН - 17)**
- 17.1 Алданги оногдуулах хувь: Гэрээний нийт дүнгийн 0.1 хувь (хоногт).
- Алдангийн нийт дүн: Гэрээний нийт дүнгийн 10 хувь.
- 10. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)**
- 21.0 Аливаа маргааныг Монгол Улсын холбогдох хуулиар шийдвэрлэнэ. Нийлүүлэгч нь Монгол Улсын хуулийн этгээд биш тохиолдолд 1976 оны НҮБ-ын Худалдааны комиссын (UNCITRAL) дүрмийн дагуу шийдвэрлэнэ. Арбитрын байгууллагын шийдвэр эцсийнх бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй болно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь _____ [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Гэрээний үнэд дараах зардлыг шингээгээгүй: (1) гаалийн импортын үед тоног төхөөрөмж, бараанд оногдуулдаг НӨАТ, гаалийн татвар, (2) захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ. Нийлүүлэгч нь гаалийн тэмдэг дарсан баглаа боодлын жагсаалт, нэхэмжлэх, тээврийн манифест зэргийг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 7 хоногийн хугацаанд гаалийн баталгаат агуулах, талбайд бараа хадгалах зардлыг Гэрээний үнэд тооцож шингээсэн.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” Дэлхийн банкны төслийн хөрөнгөөр 100 хувь санхүүжүүлнэ.
4. Захиалагч гэрээний үнийг барааг бүрэн хүлээлгэж өгсний дараа Нийлүүлэгчийн _____ банкны _____ тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

5. Нийлүүлэгч нь _____
нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Хуваарь № А: Авлигатай тэмцэх журам

Авлигатай тэмцэх журам

(Энэхүү хавсралтад заасныг тендерийн баримт бичиг гэрээний нөхцөлд өөрчлөхгүйгээр тусгана)

1. Зорилго

1.1 Дэлхийн банк (цаашид Банк гэх)-ны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт бүхий худалдан авах ажиллагаанд Дэлхийн банкны Авлигатай тэмцэх журам болон энэхүү хавсралтыг мөрдөнө.

2. Шаардлага

2.1 Банк нь зээлдэгч (Банкны санхүүжилтээс үр шим хүртэгчдийг оролцуулан); тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч болон нийлүүлэгч; аливаа туслан гүйцэтгэгч, дэд зөвлөхүүд, үйлчилгээ үзүүлэгч эсхүл нийлүүлэгч, аливаа төлөөлөгч этгээд (мэдүүлсэн эсэхээс хамааран); тэдгээрийн аливаа мэргэжилтнийг Банкны санхүүжилт бүхий гэрээний худалдан авах ажиллагааны туршид сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр стандартыг ханган ажиллах, залилан мэхлэх, авлигын үйлдлээс ангид байхыг шаардана.

2.2 Энэ хүрээнд Банк нь:

(а) Дараах нэр томъёог дор өгөгдсөн утгаар тусгасан болно. Үүнд:

- i. “Авлигын үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бус хэлбэрээр өгөхийг санал болгох, өгөх, хүлээн авах, өгөхийг шаардахыг хэлнэ;
- ii. “Залилан мэхлэх үйлдэл” гэж аль нэг тал хүлээсэн үүргээсээ зайлсхийх эсхүл санхүүгийн болон бусад ашиг олохын тулд санаатай болон санаандгүйгээр төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийгээд дээрх зорилгоор хийгдсэн зөрүүтэй тайлбарыг хэлнэ;
- iii. “Үгсэн хуйвалдах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг байдлаар хууль бус зорилгод хүрэхийн тулд хоёр буюу түүнээс дээш талууд хамтран далд тохиролцох ажиллагааг хэлнэ;
- iv. “Тулган шаардах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, эсхүл хэн нэгэн этгээд эсхүл түүний өмчид шууд болон шууд бусаар хохирол учруулах, хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ.
- v. “Саад учруулах үйлдэл” гэж

(а) Хяналт шалгалтын нотолгооны материалыг зориудаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуун дарагдуулах, эсхүл авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, албадан шахах буюу тулган шаардах үйлдлийг тогтоохоор Банкнаас хэрэгжүүлж буй хянан шалгах ажиллагаанд зориудаар саад учруулах зорилгоор асуудлыг шалгаж байгаа мөрдөгчид худал мэдүүлэх; эсхүл тухайн хянан шалгах ажиллагаатай холбогдох мэдээллийг мэдэж буй хүн өөрийг нь илчлэхээс сэргийлж айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, мөн шалгалтын дараа гарсан шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзах зэрэг үйлдэл,

(б) Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журмын Хавсралт 4-ийн 2.2 е-д заасны дагуу Банкны зүгээс хянан шалгах болон аудитын эрхээ хэрэгжүүлэхэд нь ноцтой саад учруулахаар завдах үйлдлийг хэлнэ.

(б) Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсон зөвлөх хуулийн этгээд эсхүл хувь хүн, түүний аливаа ажилтан, төлөөлөгч байгууллага, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн ажилтнууд нь уг гэрээг авах зорилгоор

өрсөлдөхдөө авлига, залилан мэхлэх, нууц үгсэн хуйвалдах, албадан шахах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэлд шууд болон шууд бусаар оролцсоныг Банк илрүүлсэн бол уг гэрээ байгуулах эрхийг цуцална;

(с) Холбогдох зээлийн гэрээнд заасан зөрчил арилгах арга хэмжээнээс гадна хэрэв Зээлдэгчийн төлөөлөл эсхүл зээлийн тодорхой хэсгээс хүртэгч этгээд нь тухайн гэрээний худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн явцад авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, тулган шаардах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэл гаргасныг Банк олж тогтоосон бөгөөд энэ үед Зээлдэгчийн зүгээс эдгээр зөрчил бүхий үйлдлийн талаар мэдсэн даруйдаа Банканд мэдээлээгүй, мөн Банкны шаардлагад нийцэхүйц байдлаар цаг алдалгүй засаж залруулахаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд уг худалдан авах ажиллагааг амжилтгүй гэж зарлан цуцалж болно;

(d) Банкны Авлигатай тэмцэх журмыг баримтлан, Банкнаас авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээний талаарх бодлого, журамд заасны дагуу хуулийн этгээд эсхүл хувь хүнийг тухайн заасан хугацааны туршид (i) Банкны санхүүжилт бүхий гэрээ хэрэгжүүлэх эрх авах эсхүл санхүүгийн болон бусад хэлбэрээр ашиг шим хүртэх²; (ii) Банкны санхүүжилт бүхий гэрээ байгуулах эрх авсан эрх бүхий хуулийн этгээдийн туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр ажиллахаар нэр нь дэвших³; (iii) Банкны зээлийн аливаа хөрөнгөөс хүлээн авах эсхүл Банкны санхүүжилт бүхий төслийн бэлтгэл болон хэрэгжүүлэх шатанд оролцохыг нь хориглон, эрх бүхий бус этгээд гэж нийтэд зарлан мэдээлж болно;

(e) Банкны зээлийн санхүүжилт бүхий гэрээний болон тендерийн/санал авах баримт бичигт (i) тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч, дэд зөвлөх, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон төлөөлөгч этгээдийн хувьд бүх данс, бүртгэл тооцоо, тендер ирүүлэх болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад бичиг баримтад Банкнаас хяналт шалгалт хийх⁴, мөн эдгээр мэдээллийг Банкнаас томилсон аудитораар хянуулахыг зөвшөөрөх тухай заалтыг тусгасан байхыг шаардана.

² Эргэлзээ үүсгэхгүйн үүднээс хориг арга хэмжээ авагдсан талын гэрээ хэрэгжүүлэх эрх бүхий бус байдалд (i) урьдчилсан сонголтод оролцох, зөвлөх үйлчилгээнд сонирхлоо илэрхийлэх, тендер шалгаруулалтад шууд оролцох болон тухайн гэрээний хувьд туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвших, мөн (ii) одоо хэрэгжиж буй гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүрээнд орж ажиллахыг хориглох нөхцөл хамаарах ба мөн үүгээр үл хязгаарлагдана.

³ Туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвшсэн этгээд (тухайн тендерийн баримт бичгийн төрлөөс хамааран ялгаатай нэрлэдэг) гэдэгт (i) тендерт оролцогчийн хувьд урьдчилсан сонголт эсхүл тендер шалгаруулалтад оролцоход нь шаардагдах чадварын шаардлагыг хангахад дэмжлэг болох чухал ач холбогдол бүхий онцгой туршлагатай, ноу хауг эзэмшсэн этгээд байх; эсхүл (ii) зээлдэгчийн томилсон этгээд байна.

⁴ Энд заасан хяналт шалгалт нь мөрдөн байцаах (жишээ нь шүүхийн) шинж чанартай байна. Эдгээрт залилан мэхлэх ба авлигын үйлдлийг тогтоохын тулд зохих механизмуудаар дамжуулан мөрдөн байцаалт/аудитын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Банкнаас хийж байгаа эсвэл Банкны томилсон төлөөлөгчөөр хийлгэж байгаа тусгай ажиллагаа орно. Үүнд дараах үйл ажиллагаа багтах бөгөөд мөн эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Тухайлбал: Хуулийн этгээд, хувь хүний санхүүгийн бүртгэл тооцоо, холбогдох мэдээллийг авч шалгах, шаардлагатай бол тэдгээрийн хуулбарыг хийх; мөрдөн байцаалт/аудитад холбоотой хэмээн тооцогдож буй бусад бичиг баримт, дата мэдээлэл (цаасан болон цахим хувилбараар), ажилтнууд болон бусад холбогдох хүмүүсээс ярилцлага авах; бодит мөрдөн байцаалтыг хийх, хэрэг болсон газарт очин биечлэн үзлэг хийх, мэдээллийг баталгаажуулах гуравдагч талын тусалцааг авах зэрэг болно.

Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)

Баталгаа хүлээн авагч: *[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

Огноо: *[баталгаа гаргасан огноог бичих]*

Дугаар: *[баталгааны дугаар бичих]*

Баталгаа гаргагч: *[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

1. *[Нийлүүлэгчийн нэрийг бичих]* (цаашид “Нийлүүлэгч” гэх) нь *[бараа үйлчилгээний товч тодорхойлолт]*-ыг нийлүүлэх зорилгоор *[Гэрээний нэр ба дугаарыг бичих]* (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн төлбөрийн үүрэг хүлээж *[баталгааны дүн тоогоор]* *[дүн үсгээр]* баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэлх хугацаанд хүчинтэй байна: гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.
6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Баталгаа гаргасан,

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг: